



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 24 өдөр

Дугаар

А/712

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Аялал жуулчлалын веб сайт, мэдээллийн төв байгуулах ажлын гүйцэтгэгч “Микролайнс” ХХК-ийн ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Л.Батбаяр - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Гишүүд: Б.Мөнхдолгор - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн

Б.Ганзориг - Хар Ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн

Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Д.Дөмөгтүшиг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Д.Дэлгэрбаяр - “Микролайнс” ХХК-ийн захирал

Нарийн бичгийн

дарга: Д.Эрдэнэбат - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Тухайн төсөл, арга хэмжээг захиалагчаас баталсан ажлын даалгавар, техникийн тодорхойлолтын дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч /Л.Батбаяр/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН

02 2526  
Zah A/712 Kh